



**ДАРХАН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН
ПАРК ОНӨ ААТУГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 1/02

Дархан

Журам батлах тухай

Дархан Үйлдвэрлэл Технологийн Парк ОНӨААТУГ-ын дүрмийн 7.1.6, 7.1.8, 7.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.1, 9.7, 9.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Дархан Үйлдвэрлэл Технологийн Парк ОНӨААТУГ-ын ажилтан, албан хаагчдын Гүйцэтгэлийн үр дүн тооцож, дүгнэх, Урамшуулал олгох журмыг боловсруулж 1 дүгээр хавсралтаар, Гүйцэтгэлийн үр дүн тооцож, дүгнэх хуудсыг 2 дугаар хавсралтаар, Үндсэн цалингийн хэмжээг 3 дугаар хавсралтаар баталсугай.

Хоёр. Дархан Үйлдвэрлэл Технологийн парк ОНӨААТУГ-ын ажилтан, албан хаагчдын Гүйцэтгэлийн үр дүн тооцож, дүгнэх, Урамшуулал олгох, Үндсэн цалингийн хэмжээ тогтоох журмыг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс мөрдлөг болгосугай.

Гурав. Ажилтан, албан хаагчдад урамшуулал, нэмэгдлийг журмын дагуу тооцон цалингийн санд багтаан бодож олгохыг Нягтлан бодогч /Х.Хонгорзул/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Журмыг ажилтнуудад танилцуулж, мөрдлөг болгон, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл технологийн мэргэжилтэн /Э.Солонго/-д даалгасугай.



ДАРГА

Х.ОТГОНБАЯР